

МОНГОЛ ХЭЛНИЙ “ХИЙХ” ХЭМЭЭХ ҮГИЙН УЧИР, ТҮҮНИЙ УТГЫН  
ӨРГӨСӨЛ БА ХЭРЭГЛЭЭНИЙ ЭРГЭН ТОЙРОН

Б. Цүрэв-Очир\*

Монгол хэлний “хийх” гэдэг үйл үгийн онтологи тал нь хүн, түүний танин мэдсэний үндсэн дээр гүйцэтгэж болдог үй олон үйл ажиллагаатай холбоотой бол, нөгөө хэлэхүйн үндэс нь хүн, түүний хэлэхүйн олон үйлдэлтэй холбоотой гэж үзэж болно. Хүн гэдэг амьтан, нэг насны явдалдаа буюу төрөөд анхны амьсгал хийх (авах)-ээс өгсүүлээд, өсөх хүртэл, өсөхөөс өглөх хүртэл, өглөхөөс үхэх хүртэл суун босон, хэвтэн тонгойн, өдөр шөнө, өглөө орой, мэрийн чарайн, энд ч тэнд ч, гэрт ч гадаа ч, өдий төдий үйл ажлыг бүтээж, гүйцэтгэж, эзэмдэж, оролцож “хийж” байдаг аж. Тэр олон үйл бүтээл нь үйлдэл ба хөдөлгөөний дохио болох “хийх” гэдэг үйл үгийн утгын оронд эргэлдэн орчиж, хүмүүний хэл-сэтгэхүйн харьцаанд илэрч байдаг хэмээн үзэж болно. Хүн гэдэг амьтан “эхийн усан өлгий”-гөөс унамагцаа л эх дэлхий-этүгэн эхтэй бие, хэл, сэтгэлээр харьцаж “амьсгал хийх”, “ход ход хийх”-ээс өгсүүлээд л өдий төдий “ажил”-ыг хийдэг ба нэг насны замд үндсэндээ хоёр л зүйлийн ажлыг бүтээдэг аж. Тэрхүү олон зүйл “хийдэг ажил”-ыг нь танин мэдэхүйн философи хийгээд тайлалзүй (херменевтик)-д “нийгэм ахуйн ажил” буюу “өдөр тутмын ажил” “түүхийн ажил” гэж хоёр хуваадаг аж. Жишээлбэл: Монгол хүний дөрвөн улирлын болон өдөр тутмын мэндчилгээнд:

- За юу хийж байна даа? эсвэл,

- Та юу аязагнаж байна даа?

- Та юу бүтээж байна даа? гэсэн үйлийн асуулт байдаг. Үүний ёс төртэй тогтсон хариу болгож:

- “Хүнээр хүн хийж явна.”, “Мал сүргээ адгуулж явна.”, “Морь тарлаж байна.”, “Хайч хурцалж байна.”, “Хонь малаа хяргаж байна.”, “Ан ав хийж байна.”, “Хутга билүүдэж байна.”, “Идэш хийж байна.”, “Давс гаргаж байна.”, “Сур элдэж байна.”, “Гэр төхөөрч байна.”, “Эсгий хийж байна.”, “Чөдөр зангидаж байна.”, “Мод хийж (цагаалж) байна.”, “Идээ цагаагаа боловсруулж байна.”, “Хурал ном хийж байна.”, “Ном зохиол бүтээж байна.”, “Карт хийж байна.” г.м олон үйл ажлаар хариу өгдөг. Энэ мэт “хийдэг олон ажил”-ыг “нийгэм-ахуйн ажил” гэдэг бол, харин “Цэндийн Дамдинсүрэн “Монголын нууц товчоо”-г одоо үеийн монгол хэлэнд хөрвүүлсэн.”, “Гэсэрийн тууж “-ийг судалсан.”, “Монголын уран зохиолын дээж зуун билэг” бүтээлийг хийж хэвлүүлсэн.”, “БНМАУ-ын төрийн сүлд дууллыг 1950 онд зохиосон.” ... гэх зэрэг бага, их “ажил”-ыг “түүхийн ажил” гэдэг байна. Энэ хоёр зүйл ажлын аль аль нь хүмүүний

\* Монгол Улсын Боловсролын Их Сургууль

## Б. Пүрэв-Очир

үйл ажиллагаа ба “хийсэн үйл”-ийн үр дүн юм. “Ажил” болгон, “хийж бүтээсэн” болгон нь монгол хэлний “хийх” гэдэг үгээр, тэрчлэн түүний “утгын орон”-ы ямар нэг ойролцоо утгат “үйл үг”-ээр л тэмдэглэгдэн илэрч, мэдээллийг зөөж тээдэг учиртай юм. Энд “ажил” “үйл” “үр дүн” буюу “хэрэг явдал” гэсэн гурвалж үүсдэг гэж үзэж болно.

Монгол хэлний үйл үгийн захирах холбоо, аливаа нэгэн үйл үгийн нөгөө үгийг нэгдүүлэн захирах, бас бусад үгтэй нийлэн нэгдэх чадамжийн тухай сэдэв бол үгийн утга судлал, хэрэглээний хэлшинжлэл, танихуйн хэлшинжлэл, хэлний нэгжүүдийн нийгэм-соёлын орчилд гүйцэтгэж байдаг үүрэг, хүний гоц чанар буюу феноментой холбоотой, олон салбар ухааны уулзвар заагт нөхцөлдсөн асуудал юм. Монгол хэлний идэвхтэй ба идэвхгүй үйл үгийн захирах чадамж, хэрэглээний хүрээний олон утга, түүний өргөсөх ба нарийсах зүй тогтлыг хам ба цуваа цагийн үүднээс төдий л сайн судлаагүй байна. Тухайлбал, “хийх” хэмээх үйл үгийн бодит ба хийсвэр олон утга, түүний өргөсөж ирсэн байдал, монгол хүний үйл ажиллагааны зам мөр, ажил ба үр дүн, өнөөгийн нийгэм-соёлын хандлага, өөрчлөлт, танихуйн хэлшинжлэл г.м олон талаас нь ажиглавал сонин зүйл олон байна. Наанадаж л “ажил хийх”, “хоол хийх”, “дайн хийх”, “гэрээ хийх”-ээс өгсүүлээд, “кесерово буюу хийсвэр хийх”, “хүнээр хүн хийх”, “зүгээрийг хийх”, “цор цор хийх”, “ход ход хийх”, “улс төр хийх”, “мөнгө хийх” хүртэлх өдий төдий нийлэмжийн хүрээн дэх “хийх” гэдэг үгийг “хүн” яаж хэрэглэж ирсэн хийгээд түүний олон утгын эргэн тойрныг сонирхоод үзэж болмоор байна. Энэ зорилгоор “хийх” үйл үгийг тэмдэглэгдэхүүний тал, хэлэгдэхүүний дохио тэмдэг болох нийлэмжүүд хийгээд, хүнээс хамаарах хэрэглээ, соёл талаас сонирхоод үзэв.

Монгол хэлний зарим үйл үгийг тусгайлан сонирхсон зүйл мэр сэр байна. Тухайлбал, эрдэмтэн Л.Ганчимэг “Тогтвортой холбоо үгийн утгыг шинжлэн ангилах аргагүйн зарим судалгаа” (МУИС, МХСС-ийн эрдэм шинжилгээний бичиг, 2008, XXVIII, 294:43-51), “Орох” хэмээх үйл үгийн нийлэмжийн утгыг ангилсан байдал, мөн Ч.Баттөгсийн магистрын судалгааны ажилд “авах” гэдэг үйл үгийг мөн утгазүйн талаас нь судалсан г.м нэг үйл үгийн судалгаанд хэлбэр ба утгаас нь санаа авмаар зүйл бас бус байна.

Эрдэмтэн М.Базаррагчаа “Үгийн гарлыг мөшгөх нь” бүтээлдээ болхи, салхи, уушги, нилх, бархирах, бахим, даахь, хумхи, идэвхи, тархи, талхих, гялсхийх, хүрсхийх, тахийх, тохийх, тухайх, найр, сайр, осгох (даарах), сайртах, булгих, сонгох гэх мэт үгс нь “хийх” үйл үг оролцож бүтсэн байх магадлалтай гэж үзсэн бий. (Базаррагчаа.М, “Үгийн гарлыг мөшгих нь” боть III, 117-р тал) Иймд “хийх” хэмээх үг нь монгол хэлний зарим үйл үгийг үүсгэх гол валент тохируулагч болдог байсан байж болох талтай юм. Харин орчин цагийн монгол хэлэнд **хий+лт, гч, ц, гд, лгэ, лц** зэрэг үг бүтээх дагавар залгаж хийлт, хийгч, хийц, хийгд, хийлгэ, хийлц зэрэг үг бүтэхээс гадна “**м**” гийгүүлэгч нэмэн давтаж, тухайн үйл болон бусад үйл хөдлөлийг багтаасан ерөнхий утгатай “**хийж мийх**” гэсэн үйл үг бүтэж байна. Үүнээс үзэхэд “**хий-**” үйл язгуур нь дагаврын аргаар шинэ үг бүтээх чадамж нь тийм ч сайн бус юм. Учир нь “**хий**” язгуур нь монгол хэлний үйл үг бүтээх гуч гаруй дагавраас дээрх зургаан дагаврыг л авч, үг бүтээх ба эдгээр үүсмэл үг нь хүмүүсийн өдөр тутмын харилцаанд төдийлөн идэвхтэй хэрэглэгдэхгүй байгаа нь мэдээлэл дамжуулахад тийм ч бүтээлч биш гэдгийг харуулж байгаа юм.

Мөн эрдэмтэн Ж.Баянсан нар (1998) бүтээлдээ “оро-” толгой үг бүхий холбоо үгийг хэлзүйн хэлбэржилтээр нь субъект-предикат, объект-предикатын харьцаатай холбоо үг гэж ерөнхийд нь хоёр ангилсанчлан (МУИС, МХСС эрдэм шинжилгээний бичиг, 2008, XXVIII, 46-р тал) монгол хэлний “**хий-**” үгтэй холбоо үгсийг хэл талаас нь тодотгогч-тодотгуулагч, тусагдахуун-өгүүлэхүүн харьцаатай хэмээн ерөнхий шинжээр нь ангилж болно. Тухайлбал:

Б. Пүрэв-Очир

**Харьцаа нь:**

(Тодотгогч- тодотгуулагчийн)

Хэлбэр нь:

(Үйл үг+нэр үг)

- Хийх ажил

Гэхдээ бидний хийх ажил дуусах болоогүй ээ. Зууны дөчин хувь дээрээ л явж байна. (“info”сэтгүүл)

- Хийх зүйл

Монголын рок, попын түүхэнд хийх зүйл маш их байна. (“tv zone”сэтгүүл, 2011.01.24-01.30 05-р тал)

- Хийх уулзалт

Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайд Т.Гандитай хийх уулзалт... (“Өнөөдөр” сонин, 2011, ' 0027)

- Хийх айлчлал

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Швейцарийн холбооны улсад хийх айлчлал эхэллээ. (Элчингийн мэдээ)

- Хийх заавар

Худалдан авалтынхаа төлбөрийг Most Money-аар хийх зааварыг эндээс үзнэ үү. (www.Torica.mn)

- Хийх сорилт

Жижиг бизнес эрхлэгчдийн хувьд судалгааг маш бага төсөвт багтааж хийх сорилт тулгардаг ...

- Хийх үйлчилгээ

Танай байгуулгын үүрэгт тохирсон энэ үйлчилгээ нь стандарт вэб хийх үйлчилгээнээс эрс ялгаатай

Гэхдээ хэлний зогсонги, хөдлөнгө харьцаанд хийх ажил ≠ ажил хийх гэсэн байдлаар тонгоргон хувиргаж болох хэлбэр байдаг. Үүнд:

- Хийх буян ≠ буян хийх
- Хийх зүйл ≠ ... зүйл хийх
- Хийх уулзалт ≠ уулзалт хийх
- Хийх айлчлал ≠ айлчлал хийх
- Хийх заавар ≠ заавар хийх
- Хийх сорилт ≠ сорилт хийх
- Хийх алхам ≠ алхам хийх
- Хийх үйлчилгээ ≠ үйлчилгээ хийх
- Хийх зааварчилгаа ≠ зааварчилгаа хийх
- Хийх арга ≠ арга хийх

**Дээрх холбоо үгс буюу нийлэмж үгсийг тонгоргон хувиргаж үзвэл:**

- Утгаараа бүрэн дүйсэн-хийх буян, хийх ажил, хийх уулзалт, хийх сорилт
- Дутмаг дүйсэн-хийх заавар, хийх алхам, хийх арга

**Харьцаа нь:**

Үйлдэгч - предикатын  
(Тусагдахуун-өгүүлэхүүн)

Хэлбэр нь:

(Нэр үг+ үйл үг)

- Хоол хийх

Цэцэг тарих, хоол хийх миний хобби (“tv zone” сэтгүүл)

- Ажил хийх

Ph.D зэрэгтэй их дээд сургуулийн профессор, судлаачид ТЕИС-д 1-6 судалгааны ажил хийх боломжтой (зар мэдээ)

- Үзлэг хийх

“Авто тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх журам”-ыг хавсралтаар баталж, 2000 оны 5-р сарын 1-ээс эхлэн мөрдөн хэрэгжүүлсүгэй (МУ дэд бүтцийн хөгжлийн сайд, ХЗС-н хамтарсан тушаал дугаар, 100/300)

- Судалгаа хийх

“Үнэлгээний мэргэжилтэн” гэж байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний үйл ажиллагаанд тодорхой чиглэлээр оролцон судалгаа хийх, үнэлгээ үнэлэлт өгөх эрх бүхий этгээдийг хэлнэ. (Баярсайхан.Ц, “Иргэн таны эрхзүйн мэдлэгт”, Уб., 2010, 134-р тал

Б. Пүрэв-Очир

- Огт дүйгээгүй- хийх зүйл, хийх арга гэсэн гурван хэв шинжийг харуулж байна. Энэ нь монгол хэлний “хийх” гэдэг үгтэй холбогдсон үг нь бодитой байх тусмаа утгаараа бүрэн дүйж, хийсвэр болох тусмаа утгаараа дүйх шинжээ алдаж байдаг гэж үзэж болмоор.

**“Хийх” хэмээх үйл үгийг Монгол хэлний тайлбар толь болон бусад судалгааны бүтээлд утгаар нь ангилсан байдал**

№	Бүтээлийн нэр ба Утгын ангилал	Ш.Цэцэн-цогт, “Монгол үгсийн язгуурын толь”, 1987	Я. Цэвэл, “Монгол хэлний товч тайлбар толь”, 1966	Норжин, “Монгол хэлний толь”, 1999	“Монгол хэлний хураангуй тайлбар толь”, 2008	Ч. Дамба-жав нар <sup>2</sup> , 2006	Д.Бадамдорж “Монгол хэлний утгазүйн сорилго, дасгал, .....
1	Үйлдэх	+	+	+	+	+	+
2	Бүтээх	+	+	+	+	+	+
3	Гүйцэтгэх	+	-	-	-	-	-
4	Агуулах	+	+	+	+	+	+
5	Багтаах	+	-	-	-	-	-
6	Зүүх, өмсөх	+	+	-	+	+	-
7	Зохиох	+	-	-	-	-	-
8	Хэрэглэх	+	-	-	-	-	-
9	Байх, болгох	+	-	-	-	-	-
10	Бий болгох	-	+	-	+	+	-
11	Бэлдэх	-	+	-	-	+	-
12	Хамжих, зэхэх	-	-	-	-	-	+
13	Оруулах	-	-	-	-	-	+
14	Хүмүүжүүлэх, асрах	-	-	-	+	-	+
15	Муу учир явдал гаргах	-	-	-	-	+	-
16	Агшин зуур болох үйлийн утга	-	-	-	+	-	-
17	Учир явдал гаргах	-	-	+	-	-	-
18	Үйл ажиллагаа явуулах, гүйцэтгэх	-	-	+	-	-	-
19	Нэгийг нөгөөд хэрэглэх, зарцуулах	-	-	+	-	-	-

Дээрх утгын ангиллыг харгалзан, “хийх” хэмээх үгийн утгазүйн шинж, хэв маягийн цөм утга ба түүний өргөслийг нягталж үзэв.

**“ Хийх “ хэмээх үйл үгийн гол буюу цөм утга нь**

1-рт, аливаа үйлийг үйлдэх утга

2-рт, аливаа үйлэнд өртөх зүйлийг бүтээх утга, жишээлбэл:

- (Үйлдэх): Хайлт хийх, нэгжлэг хийх, тайлбар хийх, үнэлгээ хийх, тодотгол хийх, цомхотгол хийх, хувьсгал хийх, өөрчлөлт хийх, харьцуулалт хийх, хэлэлцээр хийх, гэрээ хийх, дүн

<sup>2</sup> Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж, О.а., 2006.

## Б. Пүрэв-Очир

шинжилгээ хийх, хяналт хийх, зөвлөгөөн хийх, айлчлал хийх гэх мэт.

- **(Бүтээх):** Хоол хийх, даалгавар хийх, засвар хийх, цэвэрлэгээ хийх, хувцас хийх, эсгүүр хийх, чимэглэл хийх, мод хийх, эсгий хийх, боорцог хийх гэх мэт.

**“Хийх”** үйл үг нь бүтээх утга илтгэхдээ үйлдэх утгыг бас давхар агуулдаг. Учир нь аливаа үйл нь эзэн биеийн үйл оролцоогоор илэрдэг. Тухайлбал: Миний хобби бол цэцэг тарих, сайхан хоол хийх (tv zone) гэсэн энэ өгүүлбэрт буй “хоол хийх” гэсэн үйл үг нь үйлдэгч эзний үйлдэх үйл ажиллагааны үр дүнд бүтээгдэж байна гэж үзэж болно.

### “Хийх” хэмээх үгийн салаа утга нь

Үг бүхэн үгийн сангийн утгатай байдаг. Гэвч тухайн үг нь дан ганц утгатай байдаггүй бөгөөд өөр олон утгыг илэрхийлж болно. Үгийн салаа утга нь олон байлаа ч үндсэн утгатайгаа гүн бүтцийн холбоотой байдаг. Үгийн гол утга нь олон салаа утгаа хэлхэн холбосон цөм шинжтэй байдаг. Монгол хэлний **“хийх”** хэмээх үйл үг нь гол төлөв нэр үгийг захиран зохицож, салаа олон утгыг үүсгэдэг зүй тогтолтой нь харагдаж байна.

1-рт, юмыг сав суулга зэрэгт агуулах утга

2-рт, хувцас, эдлэлийг өмсөж, зүүж хэрэглэх утга

3-рт, хэрэгцээнд зориулж, ямар нэгэн юм бий болгох, бэлтгэх утга

4-рт, хамжих зэхэх утга

5-рт, сургаж хүншүүлэх утга гэх мэт, жишээлбэл:

**(Агуулах):**

• Сав суулга зэрэгт агуулах: Авдранд хийх, зууханд хийх, хайрцагт хийх, цүнхэнд хийх, аяганд хийх,

• Орон зай байрлалын хувьд харьцангуй том, жижиг багтаамжтай зүйлд агуулах: хашаанд хийх, гэрт хийх, далайд хийх (аялал), өвөрт хийх, мухарт нь хийх, далд хийх, амбаарт хийх гэх мэт

• Ямар нэгэн зүйлд уусгаж шингээхээр хийх: давс хийх (хоолонд), усанд хийх, гэх мэт **(Зүүж хэрэглэх утга)** бөгж хийх, бээлий хийх, чихэвч хийх, ээмэг хийх, бэлгэвч хийх, аппарат хийх (шүдний, сонсголын) гэх мэт

**(Бий болгох, бэлтгэх утга)** бэл хөрөнгө хийх, хань хийх, мод хийх, идэш хийх, боодог хийх г.м.

**(Хамжих ба зэхэх утга)** хээрээр нөхөр хийх, хэцээр дэр хийх, сургууль хийх, дасгал хийх, бэлтгэл хийх, дадлага хийх,

**(Сургаж хүншүүлэх утга)** хүнээр хүн хийх, нохойгоор хань хийх г.м.

### “Хийх” хэмээх үгийн олдмол утга

- Амс хийх, буулт хийх, зайлс хийх, суулт хийх, чавчаа хийх, гам хийх, доош хийх, байдалд хийх, сэлгээ хийх, мөнгө хийх, тоглоом хийх, улс төр хийх, нүүрээ хийх (газаргүй болох)

- Мөн дуу авиа дуурайх үг хэллэгтэй нийлэн дараах олдмол утгыг илэрхийлж байна. Ухас хийх, сэртэс хийх, соргос хийх, өндөс хийх, өрвөс хийх, дав хийх, лүг хийх, дуг хийх, под хийх, чад хийх, гялс хийх г.м. Иймд **“хийх”** хэмээх үйл үг нь үйлдэх, бүтээх, агуулах гэсэн үндсэн гол утгаас гадна хэрэглэх, бэлтгэх, зэхэх, сурган хүмүүжүүлэх гэсэн олдмол утгатай хэмээн үзэж болно.

### Үйлдэх утга, түүний хэв маяг

- **Ажил хийх:**

Ph.D зэрэгтэй их, дээд сургуулийн профессор, судлаачид ТЕИС-д 1-6 сарын судалгааны **ажил хийх** боломжтой.

- **Үзлэг хийх**

“Авто тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын **үзлэг хийх журам**”-ыг хавсралтаар баталж,

## Б. Пүрэв-Очир

2000 оны 5 дугаар сарын 1-нээс эхлэн, мөрдөн хэрэгжүүлсүгэй. (МУ-ын дэд бүтцийн хөгжлийн, ХЗ сайдын хамтарсан тушаал, Дугаар, 100/130)

### - Судалгаа хийх

3.1.7. “Үнэлгээний мэргэжилтэн” гэж байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний үйл ажиллагаанд тодорхой чиглэлээр оролцон **судалгаа хийх**, үнэлгээ үнэлэлт өгөх эрх бүхий этгээдийг хэлнэ. (Ц.Баярсайхан, “Иргэн таны эрхзүйн мэдлэгт”, Уб.,2004, 134-р тал)

Үүний зэрэгцээ монгол хэлэнд:

- |                        |  |
|------------------------|--|
| - Тохируулга хийх      | - Өөрчлөлт хийх                                |
| - Хайлт хийх           | - Харьцуулалт хийх                             |
| - Нэгжлэг хийх         | - Хэлэлцээр хийх                               |
| - Тайлбар хийх         | - Гэрээ хийх                                   |
| - Үнэлгээ хийх         | - Дүн шинжилгээ хийх                           |
| - Тодотгол хийх        | - Хяналт хийх                                  |
| - Цомхотгол хийх       | - Зөвлөгөөн хийх                               |
| - Сэлгээ (ротаци) хийх | - Айлчлал хийх                                 |
| - Эмчилгээ хийх        | - Засвар хийх                                  |
| - Хувьсгал хийх        | - Хулгай хийх гэх мэт холбоо үгс нь хийсвэрдүү |

үйлдэх утгыг заан хэрэглэгддэг бөгөөд эдгээр нийлэмж нь монгол хэлэнд харьцангуй хожим үүссэн, улмаар нийгэм-соёлын хандлагатай холбоотой хэрэглэгдэж байдаг.

Эдгээрээс “Хайлт хийх, нэгжлэг хийх, тайлбар хийх, үнэлгээ хийх, тодотгол хийх, цомхотгол хийх, эмхэтгэл хийх, сэлгээ (ротаци) хийх, эмчилгээ хийх, өөрчлөлт хийх, харьцуулалт хийх, хяналт хийх, айлчлал хийх” гэдгийг, зүй нь “хайх, нэгжих, тайлбарлах, үнэлэх, тодотгох, цомхотгох, эмхэтгэх, сэлгэх, эмчлэх, өөрчлөх, харьцуулах, хянах, айлчлах, засварлах” гэх ёстой бөгөөд эдгээр нь харьцангуй орчуулгын шинж чанартай, найруулгын алдаатай ч гэмээр үг хэллэг гэж үзэх хандлага байдаг.

“**Хийх**” хэмээх үйл үг нь өмнөх нэр үгээ захирахдаа заах тийн ялгалын нөхцөлийн О (тэг) хувилбараар холбогдож байна. Эдгээр үйлдэх утга илтгэж байгаа нийлэмж үгс нь эерэг ба сөрөг үнэлэмжит үр дүнгийн утга заадаг. Жишээлбэл,

- Хайлт хийх..... хайсан үр дүн гарна,
- Нэгжлэг хийх ..... нэгжсэн үр дүн гарна,
- Тайлбар хийх ..... тайлбарласан үр дүн гарна,
- Үнэлгээ хийх..... үнэлсэн үр дүн гарна,
- Эмчилгээ хийх ..... эмчилсэн үр дүн гарна,
- Хувьсгал хийх ..... өөрчлөлтийн үр дүн гарна,
- Өөрчлөлт хийх..... шинэ үр дүн гарна,
- Харьцуулалт хийх ..... харьцуулсан үр дүн гарна,
- Хэлэлцээр хийх..... хэлэлцсэн үр дүн гарна,
- Гэрээ хийх..... гэрээ хийсэн үр дүн гарна,
- Дүн шинжилгээ хийх ..... шинжилсэн үр дүн гарна,
- Хяналт хийх ..... хянасан үр дүн гарна,
- Зөвлөгөөн хийх..... зөвшилцсөн үр дүн гарна гэх мэт.

### **Бүтээх утга, түүний хэв шинж**

“Хийх” үйлийн дүнд ямар нэгэн бодит бүтээгдэхүүн гарна, жишээ нь, хоол хийх: Миний хобби бол цэцэг тарих, сайхан **хоол хийх**, даалгавраа хийх: **даалгавраа хийх** санаатай хэдэн хуудас сөхсөн, зураг зурах юм гэнэ. Хүн амьтны царай, хувцас ялгах юм байх аа, дээл хийх: Тиймээс

## Б. Пүрэв-Очир

хамгаалуулах шаардлагатай гээд, биет бус соёлын өвөөр бүртгүүлж байгаа хэрэг. Биет бус соёлын өвд бүртгүүлнэ гэдэг маань тухайн дээл хийх арга техникийг хэлээд байгаа юм.

- Хоол хийх (хоол гэж нэрлэгдэх бүтээгдэхүүн гарна)
- Даалгавар хийх (хийж гүйцэтгэсэн даалгавар гарна)
- Засвар хийх (засагдсан бүтээгдэхүүн гарна)
- Цэвэрлэгээ хийх (цэвэрлэгдсэн бүтээгдэхүүн гарна)
- Дээл хувцас хийх (хийсэн хувцас хунар гарна)
- Эсгүүр хийх (хувцас хийх үлгэр эсгүүр гарна)
- Чимэглэл хийх (чимэглэсэн эд зүйлс гарна)
- Мод хийх (бэлтгэсэн мод гарна)
- Эсгий хийх (ноосоор хийсэн бодит бүтээгдэхүүн гарна)
- Боорцог хийх (гурилан бүтээгдэхүүн гарна) г.м.

Монгол хэлний “хийх” хэмээх үйл үгэнд захирагдаж байгаа үгс нь голдуу нэр үг байх ба холбох хэрэглүүр нь заах тийн ялгалын нөхцөлийн тэг хувилбар байж, холбоо үгийн утга нь шууд тусагдахуун-өгүүлэхүүний харьцаатай байдаг нь зүй тогтол болсон байна.

Монгол хэлний “хийх” хэмээх үйл үг оролцож бүтсэн нийлэмж үгсийг бүтэц, утгын өргөслийг нь ангилж үзвэл:

### 1. Жинхэнэ нэр + хий-

- Хоол хийх
- Ажил хийх
- Ан хийх
- Судалгаа хийх
- Идэш хийх
- Нэгжлэг хийх
- Чимэглэл хийх
- Хүүхэд хийх
- Тодотгол хийх

### 2. Үйлээс нэр үг үүсгэх “-лт” дагавартай нэр үг + хий-

- Нээлт хийх
- Нөхөн сэргээлт хийх
- Буулт хийх
- Суулт хийх
- Хайлт хийх
- Хяналт хийх
- Шалгалт хийх
- Ажиглалт хийх

### 3. Харь үг + хий-

- Вэб сайт хийх
- Мониторинг хийх
- Бүүк хийх
- Секс хийх
- Кесерово (хийсвэр) хийх
- Кекс хийх
- Баннер хийх
- Аудит хийх
- Реформ хийх

- Онлайнаар хийх
- Рефрэш хийх
- 4. Тэмдэг нэр + хий-**
  - Зоригтой/ зориггүй хийх
  - Учиртай/ учиргүй хийх
  - Тогтмол хийх
  - Буруу хийх / зөв хийх
- 5. Нэр үг үйлдэх тийн ялгал + хий-**
  - Юаниар хийх
  - Араар хийх
  - Картаар хийх
  - Дураар хийх
- 6. Орон цагийн нэр + хий-**
  - Доош хийх
  - Наагуур хийх / цаагуур хийх
- 7. Дүрслэх ба дуурайх үгс + хий-**
  - Тонгос хийх
  - Гэдэс хийх
  - Өндөс хийх
  - Тас хийх
  - Гялс хийх
  - Лүг хийх
  - Дуг хийх
  - Под хийх
  - Пэд хийх
  - Чад хийх
  - Сэртэс хийх
  - Сортоос хийх
- 8. Хоршоо ба давтсан үг + хий-**
  - Пор пор хийх
  - Жиг жуг хийх
  - Шал шул хийх
  - Доог тохуу хийх
  - Найр хурим хийх
  - Халыт мулт хийх
  - Саад тотгор хийх
  - Хяналт шалгалт хийх
  - Гох дэгээ хийх
  - Халаа сэлгээ хийх
- 9. Хий+зэрэгцэхийн “- ж” нөхцөл + үйл үг + үйлийн тийн ялгал**
  - Хийж гүйцэтгэх
  - Хийж дуусах
  - Хийж бүтээх
  - Хийж оролдох

**1-р хэсгийн холбоо үг нь** хоорондоо захируулах холбоогоор холбогдож, тусагдахуун-өгүүлэхүүний харьцаа заасан байна. “Хийх” гэдэг үгтэй холбогдсон нэр үг нь гол төлөв заах тийн ялгалын нөхцөлийн тэг хувилбараар хэлбэрждэг. Тэгээд эдгээр холбоо үг нь утгын хувьд



## Б. Пүрэв-Очир

үйлдэх ба бүтээх утга илэрхийлж байна.

**2-р хэсгийн холбоо үг нь** үйл үг + үйлээс нэр үг үүсгэх-лт дагавар аван хэлбэржсэн нэр үгийг захиран холбоо үг үүсгэжээ.

- Нээ / тусах үйл үг/ + лт = нээлт

- Буу / эс тусэх үйл үг + лт = буулт

- Хай/ тусах үйл үг/ +лт = хайлт гэх мэт. Эдгээр эгнээний үгсийг харахад хийсвэр талдаа тул бэлэн бүтээгдэхүүн гарахгүй, харин үйлдсэн үйлийн үр дүн гарна.

**3-р хэсгийн холбоо үг нь** монголд нийгэм-соёлын хандлага, хөгжлийг даган орж ирэн хөрвүүлэгдэлгүй шууд утгаараа хэрэглэгдэж байгаа голдуу техник технологийн үг хэллэг нь “хийх” хэмээх үгтэй нийлж, хөлбоо үг үүсгэсэн нь сонин. Тухайн шинэ зүйлийг нэрлэсэн гадаад нэрлэлтийг ашиглагдахдаа зайлшгүй үйлшүүлэх шаардлага гардаг. Энэ тохиолдолд монгол хэлний үйл үгсээс “хийх” хэмээх үгийг авдаг зүй тогтол байна. Жишээ нь: Мониторинг хийх (хөндлөнгийн хяналт ба дотоод хяналт хийх) Тэд орон нутгийн төрийн үйлчилгээнд мониторинг хийх, төсвөө хянах, төрийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хяналт тавих мэдлэгтэй болох ажээ. “Монголын үнэн” сонин Аудит хийх (хяналт шалгалт хийх).

Free BSD үйлдлийн системд нягт боловсруулсан аюулгүй байдлын үйл явцад аудит хийх дэмжлэг орсон байгаа. (Өнөөдөр) г.м. Харин

- Вэб сайт хийх

- Бүүк хийх

- Онлайнаар хийх

- Рефрэш хийх

- Баннер хийх г.м. эдгээр үгсийг хүмүүс ашиглахдаа хэрэглээ талаас нь мэддэг боловч илтгэх утга нь төдийлөн тодорхойгүй, бас тэгээд эдгээр үгсийг хөрвүүлэн найруулгын хэрэгцээнд нэвтрүүлэх үйл ажиллагаа монголд одоогоор байхгүй байна. Өөрөөр хэлбэл, рефрэш хий, баннер хий гэх юм бол тухайн мэргэжлийн хүн ойлгоод, шууд хариу үйлдэл хийдэг боловч, монгол хэлэнд үүний утгыг тайлбарласан толь бичиг одоогоор байхгүй байна. Эдгээрийг тодорхой хүрээний хүмүүс л идэвхтэй хэрэглэдэг тул мэргэжлийн хүрээний этгээд үг хэллэгийн бүрэлдэхүүнд оруулмаар санагдана.

**4-р хэсгийн холбоо үг нь** тэмдэг нэр үндсээрээ угсруулан хамжиж, “хийх” хэмээх үйл үгэнд захирагдан холбогдсон байна. Үйлийн шинж байдлыг тэмдэг нэр нь тодотгож өгч байгаа тул энэ холбоо үг нь утгаараа шинж байдал зааж, байц-өгүүлэхүүний харьцааг үзүүлдэг онцлогтой.

**5-р хэсгийн холбоо үг нь** нэр үг нь үйлдэх тийн ялгалын нөхцөлийн ил хувилбараар хэлбэржин, үйл үгэнд холбогдохдоо шууд бус тусагдахуун-өгүүлэхүүний харьцаа заажээ.

**6-р хэсэгт байгаа** “доош хийх” гэсэн холбоо үг нь хэлц үг болон хэвшсэн хэллэг бөгөөд хүнийг дорд үзэн муу хэлэх гэсэн утгатай. Энэ хэсгийн бүтэц-загвараар хийх үйл үгэнд захирагдсан холбоо үг цөөхөн тохиолдох ба давтамж багатай.


**7-р хэсгийн**

- Сэртэс

- Сортос хийх

- Тонгос

- Өндөс



г.м. дүрслэх, дуурайх үгс нь харьцангуй бодитой бөгөөд хүний үйл хөдлөлийн илрэл шинжийг дүрсэлдэг ба утгазүйжсэн шинжтэй, тухайлбал, чад хийх гэвэл “үхэх”, под хийх гэвэл “цадлаа, болчихлоо” гэсэн утгыг илэрхийлсэн хэлц үгийг үүсгэдэг. Эдгээрээс “подхийх” гэвэл хэлцийн шинжтэй болох боловч “чадхийх” гэдэг монгол хэлний найруулгын доод зэрэгт хамаарах этгээд үгийг үүсгэж байгаа нь сонин юм.

## Б. Пүрэв-Очир

**8-р хэсгийн холбоо үг нь** мөн хоёр хэв шинжтэй бөгөөд нэг хэсэг нь чөлөөт холбоо үгийн шинжтэй, нөгөө хэсэг нь хэлц үгийн шинжтэй байна. Тухайлбал:

- Жиг жуг хийх .....далдуур ярих, муулах гэсэн утгатай
- Доог тохуу хийх .....дооглох, тоглоом хийх гэсэн утгатай хэлц
- Хальт мулт хийх.....чанаргүй, хурдан хийх гэсэн утгатай хэлц
- Хяналт шалгалт хийх, халаа сэлгээ хийх хэмээх холбоо үг нь

хоршоо үг + “**хийх**” үйл үг гэсэн бүтэцтэй бөгөөд энэ хэв шинжийн холбоо үг нь харьцангуй цөөн тохиолдож байна.

**9-р хэсгийн холбоо үг нь** бусдаасаа арай өвөрмөц бөгөөд хоёр үйл үгийг хооронд нь зэрэгцүүлэн холбох-ж нөхцөлөөр хэлбэржүүлэн, дээрх хэвшинжийн холбоо үгийг үүсгэжээ. Энэ хэв маягаар бүтсэн нийлэмж үгийн нэг онцлог нь хийх үйл үг нь “-ж” нөхцөл авч урд нь байрласан нь өнгөн талдаа зэрэгцэх утга байгаа боловч цагийн утга заасан үйлийн тодотгол шиг байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн үйлийг эхэлж хийгээд, дараа нь гүйцэтгэнэ, бүтээнэ гэсэн учирзүй хадгалагдаж буй мэт. Монгол хэлний “хийх” хэмээх үйл үг нь өөр бусад үгстэй нийлэн утга илтгэхдээ **хэлц үгийн бүрдэл хэсэгт орсон**, үлэмж давтамжтай болсон нь хэрэглээний нэг онцлог юм.

### А. Өвөрмөц хэллэг (идиом)

1. Нүүр хийх (газаргүй)
2. Даажин хийх
3. Под хийх
4. Чад хийх
5. Чавчаа хийх
6. Гам хийх
7. Доог тохуу хийх
8. Айдгаа авдартаа хийх
9. Гал дээр тос хийх
10. Гарын бээлий хийх (болгох)
11. Дайран дээр нь давс хийх (нэмэх)
12. Зангууны ноос түүж, эсгий хийх гэгчээр...
13. Нүүр хийх газраа олж ядах
14. Толгой руугаа ус хийх
15. Хөлөөрөө толгой хийх, толгойгоороо хөл хийх
16. Эд бад хийх
17. Муу хий
18. Нурууруу хүйтэн ус хийх шиг болох
19. Хар нүдэн хийх
20. Бантан хийх
21. Морин дэл дээрээс хийх
22. Тооцоо хийх (тооцоо бодох)
23. Чихэнд нь хар ус хийх
24. Ходоодныхоо мухарт хийх
25. Дайран дээр давс хийх гэгчээр
26. Түр тар хийх
27. Цурам хий
28. Пин хийх (дулаан болох)
29. Гар хөл хийх
30. Бамбай хийх
31. Ар хударгаар нь хийх
32. Нүд ирмэхийн зуур хийх

## Б. Пүрэв-Очир

33. “Зүгээр”-ийг хийх (хийх ажилгүй байх)
34. Цод хийх (шатрын хүүгээр)
35. Дуг хийх (тэмээгээр)
36. Шаг хийх (бэрс, тэрэг, мориор)
37. Дандай хийх (бэрс, тэргээр)
38. Сэлгээ (орхиороо) хийх (тэрэг ба ноёны)

### Б. Хэвшмэл хэллэг

1. Мөнгө хийх
2. Улс төр хийх
3. Араас хийх
4. Гэм зэм хийх
5. Хань хийх
6. Хүн хийх
7. Хүний үгээр үг хийх
8. Өлмий дороо хийх
9. Доош хийх
10. Хийх ч хэцүү, байх ч хэцүү
11. Хийвэл хийсэн шиг, хэлбэл хэлсэн шиг
12. Хэлдэг нь бал, хийдэг нь хор
13. Хэлсэнд нь итгэхээр, хийсэнд нь итгэ
14. Сүйд хийх
15. Хотос хотос хийх
16. Садаа хийх
17. Алдаа хийх
18. Буулт хийх
19. Жиг жуг хийх
20. Байдалд хийх
21. Амс хийх зуур
22. Сэртэс хийх
23. Сортос хийх
24. Ухас хийх
25. Зурс хийх
26. Амбиц хийх
27. Өндөс хийх
28. Буулт хийх
29. Суулт хийх
30. Дав хийх
31. Дураар хийх
32. Тонгос хийх
33. Тас хийх
34. Зайлс хийх
35. Сэлгээ хийх
36. Буулт хийх
37. Суулт хийх
38. Дав хийх
39. Дураар хийх
40. Лүг хийх
41. Борви бохис хийх/гүй

Б. Пүрэв-Очир

42. Бор зүрх бол бол хийх  
Богино хавирга шир шир хийх
43. Гангар гунгар хийх
44. Жин тан хийх
45. Хазахаас бусдыг хийдэг (хашир бөх)
46. Цор цор хийх
47. Сургууль хийх
48. Хор хийх
49. Ажил хийвэл дуустал...
50. Иг маг хийх , маг маг хийх
51. Явууллага хийх
52. Цааш нь хийх
53. Цор цор хийх
54. Шалар шалар хийх
55. Хээрээр нөхөр хийх, хэцээр дэр хийх
56. Хийх нь хэдэр, явах нь ядар

**А хэсгийн өвөрмөц хэллэг нь** утгын хувьд нэлээд хийсвэр бөгөөд үг бүр нь шууд утгаараа буугаагүй хам сэдэвтээ далд санаа, далд утга агуулсан байна. Тухайлбал: **“Муу хийх”** гэдэг өвөрмөц хэллэг нь аливаа юмыг сайн, муу хийх үйл үгийн шинж чанарыг заасан үг бус харин мал нядлах гэсэн сөрөг үнэлэмжит үйлийг хүний сэтгэл, сэтгэхүйд эерүүлж хүртээх гэсэн нэгэн далд санаатай байна.

Мөн зарим өвөрмөц хэллэг нь өнгөн талаасаа шууд утга гаргаж болмоор мэт ажиглагдаж байна. Ийм тохиолдолд өвөрмөц хэллэг үү, холбоо үг үү гэдгийг ялган танихад хам орчин шаардагдана.

Түүсэн жишээ баримтаас ажиглавал дараах өвөрмөц хэлц нь энэ шинжийг тодорхой харуулж байна.

Өвөрмөц хэлц	Хам орчингүй үед шууд илтгэх утга	Хам орчинд зүйрлэлээр илтгэх утга
Муу хийх	Аливаа зүйлийг муу үр дүнтэй хийх	Мал нядлах (жишээг хавсралтаас харна уу)
Бантан хийх	Хоол хийх	Болж бүтэхгүй зүйл хийх
Тооцоо хийх	Тоо тооцоо хийх, тооцоолох	Хүнтэй харилцаж, шийдвэрлэх утга
Толгой руугаа ус хийх	Толгой руугаа ус хийж, угаах үйл	Өөрөө өөртөө гай зовлон тарих
Гарын бээлий хийх	Гартаа бээлий хийж, өмсөх утга	Бусдыг өөрийн эрх ашгийн төлөө ашиглах

Хэвшмэл хэллэгийн баримтаас харахад, нийгэм-соёлын хандлагатай уялдан, шинээр хэвшин тогтож, давтамж ихтэй **“хийх”** гэдэг үгийн утга улам өргөсөж, хэрэглэгдэж буй үгс олон байна. Тухайлбал:

- Улс төр хийх (улс төрийн үзэл баримтлалыг ашиглан, төрд аливаа үйл хийхийг ерөнхийд нь ийнхүү нэрлэжээ), Монголын улстөрчид байгаль орчны асуудлаар **улс төр хийх** цаг нь болсон,
- Мөнгө хийх (ямар нэгэн аргаар мөнгийг бүтээн бий болгох), (ярианы хэлэнд)
- Чавчаа хийх (ямар нэгэн хоёр зүйлийн дундаас ашиг гарган авах)
- Суулт хийх (ямар нэгэн зүйлийг эсэргүүцэх, эсвэл үзэл бодлоо ойлгуулж хүргэх зорилгоор эвсэн нэгдэх хэсэг бүлэг хүмүүсийн тэмцлийн нэгэн хэлбэр)

## Б. Пүрэв-Очир

МҮОНРТ-ийн уран бүтээлчид **суулт хийх** нь (“Өдрийн сонин”, 2011.04.02, бямба гараг)

- Амбиц хийх (Энэ хэллэг нь яриа болон шар хэвлэлд олонт тохиолдож байгаа)
- Байдалд хийх (хүнийг эвгүй байдалд оруулах)

Олны өмнө тэр намайг **байдалд хийгээд...** (ярианы хэлэнд)

- Хар пиар /PR/ хийх, (хүнийг муу талаас нь нийтэд харуулах гэсэн санаатай явуулга),

Сонгуулийн штабын санхүүгийн албаны дарга З.Энхболдтой ярилцлаа.

-Сонгууль болоход арваадхан хоног үлдлээ. Хоёр нам нэгнийхээ үгийн өө хайх, **хар PR хийх** хандлага их байна гэх мэт.

Мөн энэ хэсэгт дуу чимээ дуурайх ба дүрслэх үгтэй **“хийх”** нийлж бүтсэн хэлц нэлээдгүй байна. Хотос хотос хийх, жиг жуг хийх, сэртэс хийх, сортос хийх, ухас хийх, зурс хийх, өндөс хийх, тонгос хийх, тас хийх, дав хийх, лүг хийх, жин тан хийх, цор цор хийх, иг маг хийх гэх мэт.

Энэ хэсгийн нөгөө А хэсгээс ялгагдах онцлог нь нийлж бүтсэн үгсийн бодитой утга нь гээгдэхгүй, үгчилж тайлбарлавал утгаа тодорхой хэмжээнд хадгалах чадвартай гэсэн үг. Тухайлбал:

- Хань хийх- (хань нөхөр болгох)
- Садаа хийх- (саад тотгор учруулах)
- Алдаа хийх- (алдаа гаргах)
- Сэлгээ хийх- (сэлгэх, солих утгат)
- Буулт хийх- (бууж өгөх)
- Сургууль хийх- (дасгаллах, сургуулилах)
- Бамбай хийх- (халхавч хийх, өмнөө барих)
- Хор хийх- (хор хүргэх)

А, Б хэсгийн хэлц үгсийн бүтцийг ажиглавал нэг хэсэг нь холбоо үгийн хэлбэртэй, нөгөө хэсэг нь өгүүлбэрийн шинжтэй байна. Тухайлбал: Урд нь хийсэн ганцхан алдаанаас болж, амьдрал минь үргэлж ийм байна гэж мэдсэн бол юу гэж **алдаа хийх** вэ дээ гэсэн гашуун бодол толгойд эргэлдэж байдаг юм. (“Тэр бүл” сэтгүүл) дээрх жишээнд байгаа “алдаа хийх” хэвшмэл хэлц нь угсруулах холбоогоор холбогдсон холбоо үгийн шинжтэй байна.

Харин: Найз нь бас иймэрхүү байгальд уялдсан төсөл хийх юмсан гэж бодоод л **ходоодныхоо мухарт хийчихсэн** яваа. (<http://ntsoom.blog.gogo.mn/read/entry79748/> 2010.02.06), Захирал сургуулийн ёлкон дээр дурандуулж буй муу сурсан сурагч шиг улайж, **нүүр хийх газраа олж ядна.** (А.Амарсайхан, “Золгүй учрал” шог өгүүллэг), Би **хүний үгээр үг хийх** тийм дуртай биш. Аливаа хүнтэй танилцаад, уулзаад, шудрага байгааг нь мэдэрсэн үедээ л шударга хүн гэж хэлэхээс “Тэр байна, энэ байна” гээд нэрийг нь цохож хэлэх нь учир дутагдалтай юм г.м. хэлц нь өгүүлбэрийн загвараар бүтсэн байдаг.

### **“Хийх” хэмээх үйл үг эерэг утга, үнэлэмж зааж хэрэглэгдсэн нь**

**Нэгд, үнэлэгч субъектэд:** тухайн бодгаль, бүлэг хүн, байгууллага, эсвэл улс орон, бүр цаашлаад хэд хэдэн улс, ард түмэн, нийт хүн төрөлхтөн зэргийг;

**Хоёрт, үнэлэгдэгч объектэд** материаллаг ба санаалаг, бодитой ба уран сэтгэмжийн, ерийн ба ерийн бус гэх мэт зүйлийг багтааж, харилцах, мэдээлэх, илэрхийлэх төвшинд үнэлгээ өгдөг зүй тогтолтой аж. Энэ нь холбогдох тодорхой объектын талаар тухайн субъектэд төрж буй сэтгэгдэл, бишрэл юмуу, жигшил, дүгнэлт цэгнэлтийг үг ба өгүүлбэр, эхээр дамжуулж байна.

**“Хийх”** хэмээх үйл үг нь дангаараа байхдаа аливаа үйлийг үйлдэх, бүтээх гэсэн хоёр утгатай байдаг ба бусад үгтэй нийлж, холбоо үг болон хэлц үг болохдоо олон салаа утга, өвөрмөц

## Б. Пүрэв-Очир

үнэлэмж илтгэж байна. Харин энэ хэсэгт эдгээр нийлэмж үг нь хүний сэрэх мэдэрхүйд ямар үнэлэмж, ямар нөлөөлөл үзүүлдгийг ажиглавал **үйлдэх утгын үр дүн нь эерэг үнэлэмж** заах онцлогтой.

Сөрөг үнэлэмж	Шийдвэрлэх нь	Эерэг үнэлэмж
Өвчин	Эмчилгээ хийх	Эрүүл бие
Эвдэрсэн эд юмс	Засвар хийх	Засагдсан эд юмс
Өөрчлөгдөөгүй эд юмс	Өөрчлөлт хийх	Өөрчлөгдсөн эд юмс
Тайлбарлагдаагүй зүйл	Тайлбар хийх	Тайлбарлагдсан зүйл
Тохиргоо алдагдсан	Тохиргоо хийх	Тохирсон эд юмс

гэх мэт “хийх” хэмээх үйл үгтэй холбогдон үйлдэх утга илэрхийлж байгаа холбоо үг нь сөрөг үнэлэмж, сөрөг үр дагавартай аливаа юмыг шийдвэрлэж, эерэг зүйлийг бүтээж, харилцаанд давтамж ихтэй нь харагдав.

Харин хүний үйл хөдлөл болон мэдрэмжид ямар эерэг, эсвэл ямар сөрөг нөлөөлөл үзүүлэх нь мэдэгдэхгүй буюу үр дүн нь тодорхойгүй “хийх” гэдэг үгтэй холбогдсон хэлц бус холбоо үг нэлээдгүй байна. Тухайлбал: хайлт хийх, нэгжлэг хийх, үнэлгээ хийх, хувьсгал хийх, дүн шинжилгээ хийх, хяналт хийх г. м.

### Бүтээх үйлийн үр дүн нь эерэг утга илтгэдэг нь

Жишээ	Өнгөрсөн цагаар төсгөх-сан нөхцөл авсан тохиолдолд илрэх утга нь (эерэг)	“хийх” үйл үг нь үгүйсгэх үгийг авсан нөхцөлд (сөрөг)
Хоол хийх	Хоол хийсэн	Хоол хийгээгүй
Даалгавраа хийх	Даалгавраа хийсэн	Даалгавраа хийгээгүй
Хувцас хийх	Хувцас хийсэн	Хувцас хийгээгүй
Чимэглэл хийх	Чимэглэл хийсэн	Чимэглэл хийгээгүй
Эсгий хийх	Эсгий хийсэн	Эсгий хийгээгүй

Монгол хэлний хурал хийх /хурах/, ямба хийх, буян хийх, залбирал хийх, цуглаан хийх, хамт хийх, хүнээр хүн хийх, эргэл мөргөл хийх, жин тан хийх, дом хийх гэх мэт нийлэмжийг эерэг үнэлэмж заадаг гэж үзэж болно.

**Жин тан хийх:** аливаа үйлийг сайн хийж, гүйцэтгэх

“Хийх” гэсэн үг орсон нийт 80 гаруй хэлц хэллэгийг ажиглахад эерэг утга, үнэлэмж заасан хэлц харьцангуй цөөхөн байв. Энэ нь монголчуудын сайн сайхан зүйлийг шууд нэрлэн хэлээд, харин саар зүйлийг хүний сэтгэлд илт юм бодогдуулахаар шууд хэлэлгүй тэдгээр зүйлээ утга далдлах хэлц үгээр эерүүлэн, зөөлрүүлж, “метафоржуулан” хэлдэг харилцааны соёлтой холбоотой болно.

**“Хийх” хэмээх үйл үг нь сөрөг утга, сөрөг үнэлэмж зааж хэрэглэгдэх нь**

Хүний мэдэрхүй, үйл хөдлөлд тааламжгүй байдал үүсгэхийг ерөнхийд нь сөрөг зүйл хэмээдэг. Тэгвэл энэхүү судалгааны ажлын явцад “хийх” гэсэн үйл үгтэй холбогдсон нийлэмж үгс нь бодит ба хийсвэр сөрөг утга, үнэлэмж илэрхийлдэг нь ажиглагдав.

**Бодит утга:**

❖ Аливаа үйлийн үйлдэх утга нь сөрөг байвал сөрөг үйл хөдлөл гарна.

Тухайлбал: (хулгай хийх) Улс төрийн прогнозоор парламентын 76 гишүүн сар шинийн баярын өмнөхөн хулгай хийх магадлал өндөр байна. (<http://www.xar.mn/?p=4943>- 2011.01.21), Монголчууд ан амьтны амь хороох нь нүгэл гэж үздэг тийм учраас мал гаргахтай холбоотой үгс

## Б. Пүрэв-Очир

нь мөн сөрөг үйл, сөрөг үр дүнг үзүүлдэг байна.

• **Ан хийх:** Дадал сумын хоёр иргэн ан хийх зорилгоор улсын хил зөрчин саатуулагдав.

• **Бой хийх:** За, тэгээд л хөдөө бой хийх үеэр бол амьсгалаа ч хураагаагүй малын арьсыг шувт татаад, хуулаад хаяна шүү дээ.

• **Нядалгаа хийх:** Дүүргийн нутаг дэвсгэрт амьд мал оруулах, нядалгаа хийх, амьд мал худалдан борлуулахгүй байх, зуслангийн ногоон бүсэд болон хүн амын сууршлын бүсэд гадны Аймаг, сумдаас орж ирсэн мал бүхий айл өрхийг оруулахыг 2010 оны 07 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн хориглосугай.

❖ Мөн агуулах, орших газар нь сөрөг үнэлэмжийг илэрхийлж байвал

• **Шоронд (гянданд) хийх:** Хврэлсүх нарыг шоронд хийх зорилгоор эрхийг түдгэлзүүлэх гээд байна хэмээн УИХ, Ху-намын бүлэг ойлгоод, УЕП-ын саналыг удаа дараа буцаагаад байгаа юм. (<http://www.olloo.mn/modules.php?name=News&file=print&sid=85560->)

❖ Үзүүлэх нөлөөлөл нь сөрөг байвал мөн сөрөг утга илтгэнэ.

• **Хараал хийх:** Миний хувьд зайлшгүй хараал хийх тохиолдол байдаг. Гэхдээ зарим нэгэн шиг архи цусаар биш, идээ, сүүгээр ар гэр үр хүүхдэд нь барцад авч ирэлгүйгээр зөвхөн сэтгэлд нь бодогдуулахаар л юм хийдэг. (<http://news.gogo.mn/news/print/16642/>)

**Хийсвэр утга:** Сөрөг утга илэрхийлж байгаа холбоо үг нь бүгд хийсвэр чанартайн дээр бас цөм хэлц үг байгаа нь нэлээд онцлог юм. Энэ нь монголчуудын аливаа муу муухай зүйлийг өөр зүйлээр төлөөлүүлэх, тойруулах замаар хэлж, санаа илэрхийлдэг ойлгуулдаг сэтгэлгээний онцлогтой холбоотой.

### Хэвшмэл хэллэгийн хүрээнд:

• **Мөнгө хийх:** Хувьцаагаар мөнгө хийх боломж, энэ нь тийм ч шударга аргаар бус, аливаа хууль тогтоомж ч юмуу, дагаж мөрдөх хэм хэмжээнээс гадуур, өөр аргаар баялаг бүтээх гэсэн санааг илэрхийлж, нийт олонд сөрөг мэдээлэл дамжигдаж байна.

• **Улс төр хийх:** Монголын улс төрчид байгаль орчны асуудлаар улс төр хийх цаг нь болжээ. Энэ нь төрийн эрх барьж байгаа эх баригчид ард түмний нүдэнд юм хийсэн хүний дүр эсгэн, аливаа зүйлийг хийж, бүтээж байгаа мэт дүр гаргаж байгааг ийнхүү нэрлэсэн, ерөөс, “улс төр хийх” гэдэг энэ хэллэг давтамж ихтэй болсон.

**Халтуур хийх-** ямар ч хамаагүй ажил хийж орлого олох,

**Араар нь хийх-** хүнийг далдуур муу хэлэх,

**Араандаа хийх-** хүнд хар буруу санаж, өширхөх,

**Тоглоом хийх-** хүнийг доог тохуу хийх, шоолох, зугаагаа гаргах,

Өвөрмөц хэллэгийн хүрээнд: Нүүр хийх газаргүй болох, даажин хийх, чад хийх, чавчаа хийх, гал дээр тос хийх, гарын бээлий хийх, дайран дээр давс хийх, нүүр хийх газраа олж ядах, толгой руугаа ус хийх, хөлөөрөө толгой хийх, эд бад хийх, муу хийх, нуруу руу хүйтэн ус хийх, бантан хийх, хар нүдэн хийх, тооцоо хийх, чихэнд нь хар ус хийх, дайран дээр давс хийх, түр тар хийх, гар хөл хийх, бамбай хийх гэх мэт.

Эдгээр үгс нь бүгдээр сөрөг чанартай үг биш, харин илэрхийлж байгаа цаад утга, ухагдахуун нь янз бүрийн болохгүй бүтэхгүй зэргийг илэрхийлж байдаг. Нийт жишээ баримтаас түүсэн 30-аад өвөрмөц хэллэгийн 21 нь сөрөг утга илтгэж байна. Тэгэхлээр монголчууд сайн сайхан эерэг зүйлийг шууд нэрлээд, аливаа болж бүтэхгүй сөрөг зүйлийг цээрлэхдээ хэлц үгээр далд санаагаар илэрхийлдэг ухаантай ард түмэн байна. Түүнчлэн эдгээр хэллэгээс **чад хийх, чавчаа хийх, мөнгө хийх, улс төр хийх, араар нь хийх, доош хийх, байдалд хийх, амбиц хийх, хар пиар хийх, улс төр хийх, бүүк хийх, онлайнгаар хийх, баннер хийх, рефрэш хийх, кал (call) хийх** гэх мэт нийгмийн хөгжлийн явцад шинээр үүсэж бий болсон хэллэгт “хийх” хэмээх үг нь голчлон этгээд үг хэллэгийн бүтцэд орж хэрэглэгдэж байгааг цааш судлууштай юм.

Монгол хэлний “хийх” хэмээх үйл үг, түүний олон утга, хэрэглээний өргөн их давтамжаас дараах дүгнэлтүүдийг хийв. Үүнд:

а. Мэдэгдэхүүн талаасаа буюу гүн бүтэц талаасаа аливаа юм, түүний хөдөлгөөн, орон зай, цаг хугацаа, тоо чанарын харьцаанд “хийх” гэсэн үйл үг нь олон янз утгат үйлдэгчийг эрхшээн захирах тийм чадавхтай, бодит ахуйдаа маш өргөн агуулгатай, өдий төдий ажил ба түүний зам мөр, зарцуулсан хүч энерги, “үр дүн”-тэй холбоотой байна.

б. Хэл талаасаа буюу синтагмуудын загварт, цөм бүтцээс нь харвал “хийх” гэсэн үг нь өөртөө үлэмж олон үгийг захирч цөм харьцаанд байх, эсвэл цөөнгүй үгэнд захирагдаж дагуул харьцаанд орох, хэлц хийгээд этгээд үг хэллэгийн бүрдэл болдог, бодит ба хийсвэр утга заадаг тийм валент чанар, чадамжтайгаараа бусад үйл үгээс үлэмж онцлог байна.

в. Хэлэхүй талаасаа буюу хувиргалаас нь харвал, “хийх” гэсэн үйл үг нь нийлэмж үүсгэх харьцангуй өндөр бүтээмжтэйн дээр, хам бүтэцдээ маш олон шилжсэн утгыг үүсгэж, өвөрмөц ба хэвшмэл хэлцийн бүрэлдэхүүнд ордог онцлогтой байна.

г. Хэлний хэрэглээ, нийгэм соёлын талаас харвал, “хийх” гэсэн үйл үг нь төрөл бүрийн найруулгад хамгийн их давтамжтай, эерэг ба сөрөг үнэлэмжтэйгээр хэрэглэгддэг, орчин цагийн хэл ярианы найруулгад шугаман бус хувилбар олонтой болсон байгаа нь баримтаас тодорхой харагдаж байна. Энэ нь нэг талаас физик утгаараа, бас тэрчлэн гэсэн томъёогоор илэрхийлэгддэг <<ажил>> ба <<энергийн өөрчлөлт>> гэсэн ойлголттой нөгөө талаас “хийх” хэмээх үйл үгийн нийлэмжүүд түүний эрчим долгион, хувьсал өөрчлөлт утга ба санааны хуйлралтай холбоотой юм.

Танин мэдэхүйн гносеологийн үүднээс, хүний ахуйн боломж эцэс төгсгөлгүйн учир зорилго тавих-төлөвлөх-арга хэрэгсэл (хүч) хэрэглэх - хийж бүтээх-үр дүн гаргах-хэрэглэх нь бас л төгсгөл хязгааргүй байж болох талтай. Цаашид, монгол хэлэн дэх ... хийж + байна, хийх болно, хийсэн гэнэ, хийсэн атал, хийсэн буюу, хийсэн бөлгөө, хийвэл зохино, хийж өгнө, хийлгүй яахав, хийвэл хийе, хийх ёстой, хийх хэрэгтэй, хийх хэрэггүй, хийхээс биш, хийх юм чинь, хийж чадна, хийж таараа, хийж 22 дөнгөнө, хийх санаатай, хийж амжина, хийж мэднэ, хийж орхие ... г.м үйл үгийн задлаг хам бүтэц буюу “хийх” үйл үгтэй нийлсэн хэлбэрүүдийн бүтэц, утга, үүрэг, хэрэглээ, давтамжийг, нөгөө талаар “хийх”-тэй хоршоо үгсийг тусгайлан судлах нь бас нэг “хийх ажил” гэж үзэж байна. Энэ бол монгол хэлний “хий - ” үйл үгийн учир, түүний утгын өргөтгөл, хэрэглээний эргэн тойронд холбогдож буй бас нэгэн сонин сэдэв болой.

#### ABSTRACT

**“Toward the nature of the verb “хийх”, the expansion of its meaning and the context beyond its use and exploitation in speech events”**

By “Purev-Ochir (Chancellor of MSUE on Research and Cooperation Affairs, Professor, Doctor of Science in Linguistics)

In this paper the nature of Mongolian verb “хийх” has been examined from the view of ontological and cognitive perspectives. The ontological side of the verb “хийх” can be related to humans and the variety of activities they can do. As it is considered in Linguistic and cognitive Philosophy, this kind of activities humans do can be examined as “social activities” or “everyday activities”. The cognitive roots of the verb “хийх” can be related to humans and the variety of speech events they perform. Consequently, these activities can be called as “historical activities” or “creative jobs”. Every “job” a human does, every “speech act” a human performs is as usual marked and expressed with the help of the verb “хийх” or other verbs synonymous to its “meaning space”. Due to the verb “хийх” and other verbs synonymous to its multiple meanings the messages humans wanted to pass and convey in their speech events have still been being successfully carried and transferred.



The governing capacity and multiplicity of meanings for the active and passive verbs in Mongolian, the principles for expansion and reduction of their meanings have not been studied well enough in chronological and de-chronological order until today. Consequently, to date, for example, the verb “*хийх*” in Mongolian, the expansion for its meaning has not been studied well enough, so we have tried and struggled to interest in the combinations and collocations with the verb “*хийх*” and the context behind its use and exploitation in a variety of speech events not only from the view of structural and derivational perspectives but from the view of modern applied linguistic and socio-cultural perspectives.

Although there are few research findings conducted on this phenomenon, we have made a brief research review related to the studies on some of the other individual verbs conducted by modern researchers such as L. Ganchimeg (2008), CH. Bat-tugs, M. Bazarragchaa (1992), J. Bayansan (1998) etc.,. Due to their research findings and at the same time based on the general classification concerned the meanings on the verb “*хийх*” which are done in advanced dictionaries and other research publications, we have found that it is possible to subdivide the meanings of the verb “*хийх*” into two kinds of classification due to its relation to the item being modified: Relations: (**modifier**-item being modified). The form: (**verb** “*хийх*” + **noun**): for example, “*хийх ажил*”, “*хийх зүйл*”, “*хийх айлчлал*”, “*хийх загвар*”, “*хийх сорилт*”, “*хийх үйлчилгээ*” etc.;

Relations: (**object-predicate**). The form: (noun + verb “*хийх*”): for example, “*хоол хийх*”, “*ажил хийх*”, “*үзлэг хийх*”, “*судалгаа хийх*” etc.; We think that this kind of semantic classification probably will interest all readers and researchers.

Then we have examined and viewed the semantic peculiarities and denotative meanings typical to the verb “*хийх*” in Mongolian. We have revealed that the verb “*хийх*” may have two core kinds of denotative meanings: we have analyzed (1) the instrumental meanings (үйлдэх утга) which are to be performed and their prototypes; and (2) the productive meanings (бүтээх утга) in which items are to be created or produced and their prototypes. Derived meanings of the verb “*хийх*” also have been viewed and analyzed in the article. At the same time we have made some observations on the meanings of the verb “*хийх*” when the verb has been partly included in the components of (a) complex idiomatic expressions and (b) phraseological collocations. As facts and examples gathered and observed have shown, there is a tendency where both idiomatic and phraseologically bound meanings for the verb “*хийх*” have become frequently used and exploited in social-political and colloquial speech in recent times. So we have viewed the contexts for the verb “*хийх*” beyond which its positive evaluative meanings have been analyzed versus its negative evaluative meanings. We found that it is a kind of “jobs” in the distant future to consider and explore analytical and synthetical structures of the verb as part of speech in Mongolian in general, in particular a special attention should be given to the study of the structure, meaning, function, use, exploitation and repetition of the expressions and collocations combined with the verb “*хийх*” in the for-see-able future. This would be one of the interesting research topics for young researchers within / on the nature of the verb “*хийх*” in Mongolian, the expansion of its meaning, and the context beyond its use and exploitation in a wide range of colloquial speech acts and events of Mongolians and newly established socio-political situations in Mongolia before and after the 1990s.

#### Номзүй

1. Аким. Г., Монгол өвөрмөц хэлцийн тайлбар толь. Уб., 1999.
2. Аким. Г., Монгол өвөрмөц хэлцийн тайлбар толь. Уб., 1982.
3. Баатар. Да., Монгол хэлний иж үгийн толь. Хөх хот., 1992

## Б. Пүрэв-Очир

4. Бадамдорж. Д., Монгол хэлний утга судлал, тэргүүн дэвтэр, УБ.,2001.
5. Бадамдорж. Д., Монгол хэлний утга судлал, дэд дэвтэр, УБ.,2001.
6. Бадамдорж.Д., Монгол хэлний үгийн сангийн утгазүй. УБ.,2006.
7. Бадамдорж.Д.,Монгол хэлний утгазүйн сорилго, дасгал. УБ., 2003.
8. Базаррагчаа.М., Үгийн гарлыг мөшгих нь. боть III,IV,V, УБ.,1992.
9. Базаррагчаа. М., Монгол хэлний сүегэр ба найруулбарын тухай. УБ.,1995
10. Банди. Д., Монгол хэлний утга эсрэг үгийн толь бичиг, УБ., 1994.
11. Батцогт. Д, Батзаяа. Г., Кирил монгол бичиг, УБ.,2009.
12. Батын.Ч. Ган-Өлзий., Хүмүүнлэгийн гурван ертөнцийн гоц чанарыг судлахын чандмань эрдэнэ, ШУА-ын философи, социологи, эрхзүйн хүрээлэн, УБ., 2011.
13. Бямбасан. П, нар “Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулалт”. (Үйл үгийн тогтолцоо), УБ., 1987.
14. Дамбажав. И, Алтан-Од. Д, Солонго. Д, нар “Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж”. УБ., 2006.
15. Идэрбаяр. Б., Монгол хэлний төсөөт үг, УБ.,2005
16. Лувсанвандан .С, Сумъяабаатар.Б., Монгол хэлний ойролцоо үгийн товч толь. УБ.,1966.
17. Орчин цагийн монгол хэл, Хамтын бүтээл, МУБИС , УБ.,2008.
18. Нарантуяа. Л., Шинэ үгийн толь. УБ., 2006.
19. Норжин.Ц., Монгол үгсийн тайлбар толь. ӨМАХХ.1999.
20. Өнөрбаян. Ц., Орчин цагийн монгол хэлний үгзүй. УБ.,1998.
21. Пүрэв-Очир.Б., Үг өгүүлбэрийн амь амьдрал, эрчим долгион, соёл, хэрэглээ. УБ.,2011, 8-р дэвтэр,
22. Пүрэв-Очир.Б., Монгол хэлний бүтэц, утга, үүрэг, хэрэглээ.УБ., 2007, 6-р дэвтэр.
23. Пүрэв-Очир.Б., Үг, өгүүлбэрийн амьдрал араншин, эрчим энерги, соёл хэрэглээ. УБ., 2009, 7-р дэвтэр.
24. Пюрбеев Г.Ц.,Глагольная фразеология монгольских языков. М., 1972.
25. Соёлмаа.Ч., Орчин цагийн монгол хэлний ижил үгийн толь.УБ.,2002.
26. Төмөрцэрэн. Ж., Орчин цагийн монгол хэлний үгийн сангийн судлал” УБ.,1964.
27. Ууганбаяр. Л., Монгол хэлний хийх гэдэг үгийн утга, үүрэг, хэрэглээ түүний найруулгын үүрэг. УБ., МОСС, дипломын ажил, 2011
28. Цэвэл. Я.,Монгол хэлний товч тайлбар толь. УБ.,1966.
29. Цэцэнцогт. Ш., Үгийн язгуурын толь. ӨвөрМонголын Ардын хэвлэлийн хороо,1987.
30. Шагж.С., Монгол үгийн тайлбар толь. Хөххот., 1994.
31. Эрдэнэбат.Ц.,Монгол хэлний уугал үгийн утга. УБ.,2005.

### Бусад хэрэглэгдэхүүн

- “Өнөөдөр” сонины 2011.01.31 даваа №027,028 /4191,4192/-2011.03.23 лхагва № 051/4243/
- [www.google.mn](http://www.google.mn)
- [www.news.mn](http://www.news.mn)
- [www.sanhuu.mn](http://www.sanhuu.mn)
- [www.dayarmongol.mn](http://www.dayarmongol.mn)
- [www.biiirbeh.mn](http://www.biiirbeh.mn)
- [www.gogo.mn](http://www.gogo.mn)
- “Хүмүүний амьдрал” сэтгүүл, № 08, № 06.
- “Tv zone” сэтгүүл
- “Нууц” сэтгүүл